

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ДАРГА,
АХМАД Х.БАТБАЯР ТАНАА

2021.02.25 № 07/564
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 92.0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,021,655.77</u>	<u>43,128,793.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,000.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	50,000.00	-
3121	Төгрөг	50,000.00	-
31211	Төрийн сангийн харилцах	50,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	38,971,655.77	43,128,793.77
351	Түүхий эд материал	1,648,000.00	-
35110	Тусгай зориулалттай материал	1,648,000.00	-
354	Хангамжийн материал	37,323,655.77	43,128,793.77
35410	Бичиг хэргийн материал	654,920.00	9,360,396.00
35420	Аж ахуйн материал	23,569,914.00	23,566,482.77
35440	Түлш, шатах тослох материал	34,000.00	712,700.00
35450	Барилгын засварын материал	4,067,921.77	-
35470	Бусад хангамжийн материал	8,996,900.00	9,489,215.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>45,936,287.91</u>	<u>34,754,870.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,936,287.91	34,754,870.38
392	Биет хөрөнгө	44,743,621.34	34,449,742.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,000,000.00	43,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,525,000.00)	(43,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,799,817.60	70,015,667.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,812,316.33)	(48,021,876.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,536,946.00	33,403,936.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,255,825.93)	(20,947,985.49)
393	Биет бус хөрөнгө	1,192,666.57	305,128.29
39301	Програм хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,245,025.74)	(4,132,564.02)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>84,957,943.68</u>	<u>77,883,664.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>50,000.00</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,000.00	-
413	Өглөг	50,000.00	-
4136	Бусад өглөг	50,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	50,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>84,907,943.68</u>	<u>77,883,664.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	84,907,943.68	77,883,664.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,997,652.44	38,997,652.44
51101	Өмч: - төрийн	38,997,652.44	38,997,652.44
512	Хуримтлагдсан үр дүн	45,910,291.24	38,886,011.71

51210	Өмнөх үеийн үр дүн	45,910,291.24	45,910,291.24
51220	Тайлант үеийн үр дүн		-7,024,279.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	84,957,943.68	77,883,664.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	404,337,900.00	377,215,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,088,700.00	629,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,088,700.00	629,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,088,700.00	629,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,088,700.00	629,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	403,249,200.00	376,585,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,249,200.00	376,585,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,249,200.00	376,585,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	419,289,548.33	384,239,379.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,289,548.33	384,239,379.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,429,341.23	383,534,267.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,683,620.43	315,284,466.95
210101	Үндсэн цалин	192,577,220.43	211,178,066.95
210102	Нэмэгдэл	102,106,400.00	102,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	1,000,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,852,072.47	6,480,520.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,852,072.47	6,480,520.97
2104	Хангамж, бараа материалын зардал	24,573,200.00	20,248,348.00
210401	Бичиг хэрэг	1,240,150.00	927,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,062,100.00	12,105,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	963,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	595,000.00	441,200.00
210408	Бараа материал акталсны зардал	2,375,950.00	5,811,148.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,471,000.00	1,227,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000.00	231,600.00
210604	Урсгал засвар	5,470,000.00	996,100.00
2107	Томилолт, зочны зардал	17,194,000.00	1,085,000.00
210702	Дотоод албан томилолт	17,194,000.00	1,085,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,442,100.00	5,896,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,660,000.00	2,114,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	277,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,213,348.33	33,311,931.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,897,340.00	13,714,764.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,316,008.33	19,465,967.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,860,207.10	705,112.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	705,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	705,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,860,207.10	112.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,860,207.10	112.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,951,648.33)	(7,024,279.53)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,951,648.33)	(7,024,279.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>403,299,200.00</u>	<u>376,585,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	50,000.00	-
120009	Бусад орлого	50,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	403,249,200.00	376,585,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,249,200.00	376,585,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,249,200.00	376,585,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>395,628,200.00</u>	<u>368,351,250.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	395,628,200.00	368,351,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,767,992.90	367,646,137.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,683,620.43	315,284,466.95
210101	Үндсэн цалин	192,577,220.43	211,178,066.95
210102	Нэмэгдэл	102,106,400.00	102,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	1,000,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,852,072.47	6,480,520.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,852,072.47	6,480,520.97
2104	Хангамж, бараа материалын зардал	19,827,200.00	14,697,000.00
210401	Бичиг хэрэг	560,000.00	1,023,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,372,200.00	12,269,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	963,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	595,000.00	441,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,449,000.00	2,246,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,379,000.00	715,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	5,470,000.00	931,200.00

2107	Томилолт, зочны зардал	17,194,000.00	1,085,000.00
210702	Дотоод албан томилолт	17,194,000.00	1,085,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,442,100.00	5,946,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,660,000.00	2,164,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	277,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,320,000.00	21,906,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	320,000.00	131,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,000,000.00	21,775,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,860,207.10	705,112.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	705,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	705,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,860,207.10	112.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,860,207.10	112.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,671,000.00</u>	<u>8,234,550.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,621,000.00	8,284,550.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,621,000.00	8,284,550.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,621,000.00	8,284,550.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,621,000.00	8,284,550.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,621,000.00)</u>	<u>(8,284,550.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	50,000.00	(50,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	50,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	60,861,939.57	99,859,592.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,997,652.44	60,861,939.57	99,859,592.01
Тайлант үеийн үр дүн		-14,951,648.33	-14,951,648.33
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	45,910,291.24	84,907,943.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,997,652.44	45,910,291.24	84,907,943.68
Тайлант үеийн үр дүн		-7,024,279.53	-7,024,279.53
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	38,886,011.71	77,883,664.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	376,585,800.00	376,585,687.92	112.08	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,585,800.00	376,585,687.92	112.08	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,880,800.00	375,880,687.92	112.08	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,284,500.00	315,284,466.95	33.05	99.9
210101	Үндсэн цалин	211,178,100.00	211,178,066.95	33.05	99.9
210102	Нэмэгдэл	102,106,400.00	102,106,400.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,480,600.00	6,480,520.97	79.03	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,480,600.00	6,480,520.97	79.03	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	14,697,000.00	14,697,000.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	1,023,300.00	1,023,300.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	12,269,100.00	12,269,100.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	963,400.00	963,400.00	-	100.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	441,200.00	441,200.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,531,200.00	10,531,200.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	600,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	931,200.00	931,200.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,085,000.00	1,085,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,085,000.00	1,085,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,896,300.00	5,896,300.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,114,200.00	2,114,200.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	277,100.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,906,200.00	21,906,200.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,200.00	131,200.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,775,000.00	21,775,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	705,000.00	705,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	705,000.00	705,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	705,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	376,585,800.00	376,585,912.08	(112.08)	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	376,585,800.00	376,585,912.08	(112.08)	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	376,585,800.00	376,585,912.08	(112.08)	99.9
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	-	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга, ахмад Х.Батбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 22-наас 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Үндэсний аудитын газар “Голден пэйж Аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Долгормаа аудиторын туслах Б.Ариунтуяа, чанарын хяналтыг Д.Дашням нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн газрын алсын хараа нь Олон улсын жишиг, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжлийн өндөр чадвартай ажилтан бэлтгэх юм. Эрхэм зорилго: нийгэмшүүлэх ажлын хүрээнд хүмүүжигчдэд мэргэжлийн боловсрол олгож, ажлын байраар хангах гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх, эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн ур чадвартай ажилтан бэлтгэхэд оршино.

Тус төв нь Боловсрол, шинжлэх ухааны яамны 2012 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн №2012/009 дугаар сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу дараах чиглэлээр сургалт зохион байгуулж байна. Үүнд:

- Барилгын цахилгаанчин
- Барилгын засал чимэглэлчин
- Барилгын сантехникч
- Барилгын өрөг угсрагч
- Барилгын мужаан
- Бетон арматурчин
- Гагнуурчин
- Тогооч

ШШГЕГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Б/487 дугаар тушаалаар төвийн бүтэц орон тоонд өөрчлөлт орж “Удирдлага санхүү аж ахуй”,

“Сургалтын алба” гэсэн бүтцээр 22 алба хаагчийн орон тоотой ажиллаж байгаад ШШГЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар уран дарханы багш орон тоо хасагдаж, нийт 21 алба хаагчийн орон тоотойгоор ажиллаж байна. Үүнд:

- Удирдлага, санхүү, аж ахуй-6: Төвийн захирал, ахлах нягтлан бодогч, сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав, жолооч
- Сургалтын алба-15: Сургалтын албаны менежер, сургалтын арга зүйч, барилгын өрөг угсрагчийн багш-1, сантехникийн багш-1, засал чимэглэлийн багш-2, бетон арматурын дадлагын багш-1, цахилгааны онол дадлагын багш-1, мужааны онол дадлагын багш-1, тогоочийн онол, дадлагын багш-1, гагнуурын онол, дадлагын багш-2, оёдлын технологийн багш-1, арьсаар гар урлалын зүйл урлаач багш

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Ординат” ХХК-ийн боловсруулсан “Юникус” санхүүгийн программ хангамж ашигладаг байна. ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлчилгээний төвд дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт үйлчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 384,239.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,684.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,074.3 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал 4,157.1 мянган төгрөгөөр өссөн, үндсэн хөрөнгө 11,181.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	50.0	0	-50.0
Авлага	0	0	0
Урьдчилгаа тооцоо	0	0	0
Бараа материал	38,971.6	43,128.8	4,157.1
Үндсэн хөрөнгө	45,936.3	34,754.8	-11,181.4
Нийт хөрөнгө	84,957.9	77,883.6	-7,074.3
Өр төлбөр	50.0	0	-50.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	84,907.9	77,883.6	-7,024.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	84,957.9	77,883.6	-7,074.3

Бараа материалын дансны үлдэгдэл 43,128.8 мянган төгрөг болж 4,157.1 мянган төгрөгөөр өссөн нийт 59,872.3 мянган төгрөгийн худалдан авалт, 55,715.1 мянган төгрөгийн зарцуулалтын зөрүүнээс үүссэн байна.

Алба хаагчид болон суралцагчдын ашиглагдаж байгаа хөрөнгүүдийг бүртгэл тусгаж эргэлтийн хөрөнгөнд хяналт хийх боломжийг хангасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 34,754.8 мянган төгрөг болж 11,181.4 төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл 19,465.9 мянган төгрөгийн зардлаас шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр 8,284.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 313 дугаар тогтоолоор 6,201.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн актлах асуудал саналын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөл дор зохион байгуулж акталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 114.3 мянган төгрөг бараа материал, шатахууны урамшуулалд 515.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсаныг бүртгэж орлогоор тусгасан байна.

Биет бус хөрөнгө хорогдуулалтын дүнгээр буурсан болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 77,883.6 мянган төгрөг болж 7,024.3 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн буурсанаас шалтгаалжээ.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 27,122.0 мянган төгрөгөөр буюу 6.8

хувиар буурсан нь улсын төсвөөс олгох санхүүжилт буурсан, өмнөх онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс бага дүнтэй хөрөнгө хүлээн авснаас шалтгаалжээ.

Нийт үйл ажиллагааны орлогын дүн 377,215.0 мянган төгрөг нийт үйл ажиллагааны зардлын дүн 384,239.3 мянган төгрөг байгаа нь орлогын бууралт харагдаж байна.

Нийт зардал өмнөх оноос 35,050.1 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар санхүүжилт буурсантай холбоотойгоор томилолтын зардал 16,109.0 мянган төгрөг, эд хогшилын зардал 4,243.3 мянган төгрөг, хангамжийн материалын зардал 4,324.8 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардал 25,901.4 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 7,024.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь хуримтлагдсан үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 376,585.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 376,585.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 0.2 мянган төгрөгөөр бууруулж 376,585.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 376,585.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 376,585.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 376,585.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 376,585.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь оруулсан, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,111.1 мянган төгрөгийн албан шаардлага, 22,769.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Гүйцэтгэлийн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	3,111.1	1	3,111.1	-	-	100
Зөвлөмж	1	22,769.7	1	22,769.7	-	-	100
Нийт дүн	2	25,907.8	2	25,907.8	-	-	100

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд илрээгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.22	Аудитын нэр: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/166/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: ШШГЕГын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1		-	-		
	ДҮН	0			